



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАНКНЫ БАТАЛГААГҮЙ УРЬДЧИЛГАА САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ЗӨРЧЛИЙГ
ТАСЛАН ЗОГСООЖ, ТӨСВИЙН ХӨРӨНГИЙГ ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ
ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СБА-2026/05-16/ШТА-НА

Баруун-Урт 2026 он



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn
Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор Н.Болдбаатар

Утас: 70512127 Цахим хаяг: oyunboldg@audit.gov.mn
Аудитор Э.Алтансүх

Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Аудитор Б.Ганцэцэг

Утас: 70512127 Цахим хаяг: gantsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоолын дагуу хийв.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг АИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ.</p>
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч нар, тэдгээрийн харьяа байгууллагууд болон ГХБХБГ, Сүхбаатар хот байгуулалт, орон сууц, барилга захилагч ОНӨААТҮГ, зураг төслийн компаниуд зэрэг холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглаж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Болдбаатар, аудитор Э.Алтансүх, Б.Ганцэцэг нар 2026 оны 02 сарын 12-ны өдрөөс 5 сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаанд аудитыг гүйцэтгэв.</p>

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДУУЛАН ТӨЛӨВЛӨСӨН БОЛОВЧ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫН ҮНЭЛГЭЭ, ӨРТГИЙН ТООЦООНЫ ҮНДЭСЛЭЛ, ҮР ДҮНГИЙН БАРИМТЖУУЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1.1. Сүхбаатар аймагт 2025 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх бодлогын чиглэлтэй уялдсан байна.

1.1.1. 2025 онд Сүхбаатар аймаг болон Сүхбаатар сумын ИТХ-аар баталсан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь орон нутгийн хөгжлийн хэрэгцээ, салбарын тэргүүлэх чиглэл, аймгийн бодлогын баримт бичиг болон Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөтэй нийцүүлэн төлөвлөгдсөн байна.

1.1.2. Тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн боловч бодит хэрэгцээнд тулгуурласан эсэхийг нотлох баримт хангалтгүй байна.

1.1.3. ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах зардлыг төсөвт тусгаснаар дараа оны хөрөнгө оруулалтын бэлтгэл ажлыг хангасан байна.

1.1.4. Төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг журам, аргачлалын дагуу тодорхой хэмжээнд тооцож эрэмбэлсэн байна.

1.2. Төсөл, арга хэмжээг бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн ч ТЭЗҮ, тоног төхөөрөмжийн өртгийг бүрэн үндэслээгүй, зарим төслийн санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилаагүй нь төлөвлөлтийн үндэслэл, хэрэгцээ шаардлагын үнэлгээг бууруулж байна.

1.2.1. Төсөл, арга хэмжээг шаардлагатай баримт бичгийн бүрдлийг ханган үе шаттай төлөвлөсөн байна.

1.2.2. ТЭЗҮ, цахим систем, тоног төхөөрөмжийн төсөвт өртгийг ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, үнийн судалгаа, тооцоололд үндэслэн төлөвлөсөн байдал хангалтгүй байна.

1.2.3. Шинээр батлагдсан төсөл, арга хэмжээг 2025–2026 онд буюу 2 жилд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь Төсвийн тухай хуульд заасан гурван жилд багтаан санхүүжүүлж дуусгах зохицуулалтын хүрээнд байна.

1.2.4. Шилжих төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг төлөвлөж хуваарилсан байна.

1.2.5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг PIMIS системээр хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт бүрдсэн боловч орон нутагт бүрэн жигд нэвтрээгүй, Сангийн яамны нэгдсэн бодлогын хүрээнд үе шаттай хэрэгжиж байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ ҮЕ ШАТ ХУГАЦААНЫ ДООД ШААРДЛАГЫГ ХАНГАЖ, ГОМДОЛ МАРГААН ГАРААГҮЙ БОЛОВЧ ТӨЛӨВЛӨЛТ, ТББ, ҮНЭЛГЭЭ БОЛОН ЦАХИМ СИСТЕМИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.

2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тендерийн баримт бичиг боловсруулах болон тендер үнэлэх үе шатанд тавих дотоод хяналт хангалтгүйгээс зарим ТББ хууль, журамд бүрэн нийцээгүй, шаардлага хангаагүй тендер шалгарсан нь худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөөнтэй, үр ашигтай зохион байгуулах нөхцөлийг алдагдуулсан байна.

2.1.1. Тендер шалгаруулалтыг 05 дугаар сарын 31-ний дотор дуусгах төлөвлөлтийн шаардлагыг хангаагүй 3 төсөл, арга хэмжээ байна.

2.1.2. Захиалагч техникийн тодорхойлолт, түүний иж бүрдэл бусад баримт бичгүүдийг худалдан авах ажиллагааны байгууллагад албан бичгээр хүргүүлж хэвшээгүй байна.

2.1.3. Зарим төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын баримт бичгийг жишиг баримт бичиг, хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй байна.

2.1.4. Хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулаагүй 4 төсөл, арга хэмжээ байна.

2.1.5. Тендерийн үнэлгээний шатанд тендерийн баримт бичигт заасан бүх шаардлагыг нэгэн зэрэг хангаагүй тендерийг шаардлагад нийцсэн гэж үнэлэн гэрээ байгуулах эрх олгосон байна.

2.2. Худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол, маргаан гараагүй ч цахим системийн хяналт-шинжилгээ, ашиглалт, сайжруулалтын чиг үүргийн хэрэгжилт сул байна.

2.2.1. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол гараагүй байна.

2.2.2. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол гараагүй тул Сангийн яамны шийдвэрийн хэрэгжилт, холбогдох арга хэмжээний биелэлтийг үнэлэх нөхцөл үүсээгүй байна.

2.2.3. Цахим системийн ашиглалт, сайжруулалт, аюулгүй ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байгаа нь холбогдох журмаар тогтоосон чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

БҮЛЭГ 3. ЗАХИАЛАГЧИЙН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ТЕХНИКИЙН ХЯНАЛТ, ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ БОЛОН САНХҮҮЖИЛТИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙСНААС ХЭРЭГЖИЛТ УДААШРАХ, ТӨСВИЙН АЛДАА ГАРАХ, ЧАНАРЫН ДОГОЛДОЛ ИЛРЭХ, БАТАЛГААГҮЙ УРЬДЧИЛГАА ОЛГОСОН БАЙНА.

3.1. Төсөл, арга хэмжээг хугацаанд нь, гэрээний нөхцөл болон батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлэхэд тавих захиалагчийн хяналт сул байснаас хэрэгжилт удааширч, төсвийн алдаа, чанарын доголдол, баталгаагүй урьдчилгаа олгосон зэрэг зөрчил илэрлээ.

3.1.1. Сүхбаатар сумын Малжуулах хөтөлбөрийн төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг үндэслэлгүйгээр сунгасан байна.

3.1.2. Банкны баталгаагүйгээр урьдчилгаа олгох, техникийн тодорхойлолтод заасны дагуу нийлүүлэгдээгүй барааны санхүүжилтийг олгосон зэрэг зөрчлүүд илэрлээ.

3.1.3. Хяналтын төсвийг алдаатай хийсэнтэй холбоотойгоор 2 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хүндрэл үүссэн байна.

3.1.4. Чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө 1 төсөл, арга хэмжээний чанарын доголдолд үзлэгийг захиалагчийн зүгээс хийж, үүрэг даалгавар өгсөн байна.

3.2. Барилгын ажлын явцад техникийн хяналт тавьсан боловч ашиглалтад орсон зарим ажлын доголдолд тавих дараагийн хяналт хангалтгүй байна.

3.2.1. Барилга, замын ажлын хэрэгжилтийн явцад зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг баталгаажуулах холбогдох баримт материалыг бүрдүүлсэн байна.

3.2.2. Барилга байгууламжийн бетоны бат бэх, материалын сорилт, шинжилгээг эрх бүхий байгууллагаар хийлгэж ажилласан байна.

3.2.3. Улсын комиссын өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тодорхой, дэлгэрэнгүй бөглөх, биелэлтийг нотлох баримтуудыг хангалттай бүрдүүлэх шаардлагатай байна.

3.2.4. Зарим барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг байршуулаагүй болон стандартад нийцээгүй самбар байршуулсан байна.

3.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнд бодлогын зорилтот үр дүнд хүрэх нөхцөл бүрдсэн байна.

3.3.1. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусган, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгч зориулалтын дагуу ашиглаж байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүн тодорхой хэмжээнд хэрэгжсэнийг харуулж байна.

3.3.2. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний нөхцөлд тодорхой ахиц гарсан боловч үр дүн, үр нөлөөг шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй харьцуулан үнэлж тайлагнаагүй байна.

3.3.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнд бодлогын зорилтот үр дүнд хүрэх нөхцөл бүрдсэн байна.

3.3.4. Өмнөх аудитын шийдвэрүүдээс 2 зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, үлдэгдэлтэй байна.

---oOo---

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. ОНТХО-ын төсөл, арга хэмжээ нь бодлогын баримт бичигтэй нийцсэн боловч хэрэгцээ шаардлагын үндэслэл, өртгийн тооцоо, техникийн тодорхойлолт, эрэмбэлэлтийн нотлох баримт хангалтгүй байгаа нь төлөвлөлтийн үндэслэл бүрэн хангагдаагүй байна.
2. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороо байгуулах, тендер зарлах, үр дүнг нийтлэх ажиллагаа хугацаа алдсан, техникийн тодорхойлолт болон иж бүрдэл баримтыг албан бичгээр хүргүүлээгүй нь худалдан авах ажиллагааны бэлтгэл, төлөвлөлтийн хяналт хангалтгүй байгааг харуулж байна.
3. Зарим тендерийн баримт бичигт гэрээний тусгай нөхцөл, хүний нөөц, техник тоног төхөөрөмж, тусгай зөвшөөрөл, материалын чанар, сорилт шинжилгээ, баталгаат үйлчилгээний шаардлагыг төсөл, арга хэмжээний онцлогт нийцүүлэн бүрэн тусгаагүй нь өрсөлдөөний чанар, гүйцэтгэгчийн чадавхыг бодитой үнэлэх боломжийг хязгаарласан байна.
4. Тендерийн үнэлгээний шатанд ТББ-ын бүх шаардлагыг нэгэн зэрэг хангаагүй оролцогчийг шаардлага хангасан гэж үнэлж гэрээ байгуулах эрх олгосон, мөн ирүүлсэн төсөв, техникийн санал нь зураг төсөв, хяналтын төсөв, гэрээний нөхцөлтэй зөрсөн тохиолдол гарсан нь үнэлгээний хорооны хяналт, баталгаажуулалтын горим хангалтгүй байгааг харуулж байна.
5. Гүйцэтгэлийн санхүүжилтийг бодит гүйцэтгэл, хүлээн авсан акт, урьдчилгаа төлбөрийн банкны баталгаагүйгээр олгосон, зарим ажлыг дутуу болон чанарын доголдолтой хүлээн авсан, хөрөнгийн бүртгэл ба үр дүнгийн тайлагнал бүрэн хийгдээгүй нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хөрөнгийн эзэмшил ашиглалт болон бодлогын үр нөлөөг үнэлэх боломжийг хязгаарлаж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

АЗДТГ-ын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэст:

1. ОНТХО-ын төсөл, арга хэмжээг батлуулахын өмнө хэрэгцээ шаардлагын үнэлгээ, техникийн тодорхойлолт, зураг төсөв, өртгийн задаргаа, зах зээлийн үнийн судалгаа, эрэмбэлэлтийн үнэлгээний нотлох баримтыг бүрэн бүрдүүлэх, уг баримт бичгийн бүрдэл, үндэслэлд тавих хяналтыг хэрэгжүүлэх, мөн цаашид бараа, тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн тооцоо, судалгааг иж бүрэн баримтжуулж, архивын хууль тогтоомжийн дагуу хадгаламжийн нэгж болгон архивд шилжүүлж байх.
2. Урьдчилгаа санхүүжилт, гүйцэтгэлийн болон эцсийн санхүүжилтийг олгохдоо “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3.2.4.(төсөл, арга хэмжээний гэрээний удирдлагыг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн санхүүжилтийг хянан баталгаажуулах, энэ журмын холбогдох хавсралтад заасан маягтын дагуу хяналтын хуудас хөтлөх) дахь заалтын дагуу хяналтын хуудсыг иж бүрэн, үнэн зөв хөтөлж, төрийн сангийн гүйлгээг хийлгэхдээ хяналтын хуудасны дагуу баримтыг иж бүрэн хавсаргаж байх.
3. “Зөөврийн наадмын талбай /Дарьганга сум/” төсөл, арга хэмжээний хээрийн үзвэрийн асраас 76,950.0 мянган төгрөгийн үнэтэй 1 ширхгийг дутуу нийлүүлсэнтэй холбоотой асуудлыг дахин нягталж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
4. “Төрийн албаны машины парк шинэчлэлийн хүрээнд автомашин худалдан авах” төсөл, арга хэмжээний хүрээнд LC300 GX.R Petrol High, AT /Leather/ автомашины техникийн тодорхойлолтод заагдсан өвлийн 4 дугуй нийлүүлэгдээгүй асуудлыг дахин нягталж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
5. Аймгийн нэгдсэн эмнэлгийн засварын дутуу гүйцэтгэл, чанарын доголдол, дээврийн ус нэвчилт, гэрэлтүүлэг, цахилгааны ажлын зөрчлийг Улсын комиссын үүрэг даалгаврын дагуу бүрэн арилгуулж, биелэлтэд хяналт тавьж, нотлох баримтаар баталгаажуулж ажиллах.
6. “Нийгмийн даатгалын хэлтсийн зүүн урд уулзвараас Асгат сумын чиглэлд гарах замын засвар шинэчлэлт /Баруун-Урт сум/” төсөл, арга хэмжээний хувьд асфальт бетон хучилтын нягтаршил, зузаан, найрлага, битумын агууламж, гадаргуугийн тэгш байдал, ус зайлуулах налуу мөргөжлийн байгууллагаар шалгуулж, шаардлага хангаагүй хэсгийг гүйцэтгэгчээр өөрийн зардлаар засварлуулан, лабораторийн дүгнэлт, фото баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийн болон чанарын асуудлыг гүйцэтгэгчээр арилгуулах.

Сүхбаатар аймгийн Худалдан авах ажиллагааны газарт:

1. Төсөл, арга хэмжээ бүрийн худалдан авах ажиллагааны бэлтгэл үе шатыг хугацааны нарийвчилсан төлөвлөгөөтэй болгож, үнэлгээний хороо байгуулах, ТББ боловсруулах, тендер зарлах, үнэлэх, үр дүн нийтлэх ажиллагааг хууль, журамд заасан хугацаанд дуусгах дотоод хяналтыг сайжруулж, захиалагчаас техникийн тодорхойлолт, зураг төсөл болон холбогдох бусад баримт бичгийг албан бичгээр авч байх.
2. Тендерийн баримт бичигт гэрээний тусгай нөхцөл, хүний нөөц, техник тоног төхөөрөмж, материалын чанарын гэрчилгээ, лабораторийн сорилт, баталгаат засвар үйлчилгээ, нийлүүлэлтийн хугацаа, гүйцэтгэлийн нотлох баримтыг төсөл, арга хэмжээний онцлог, зураг төсөв, техникийн тодорхойлолттой уялдуулан тодорхой тусгаж хэвших.
3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендерт оролцогчийн ирүүлсэн техникийн санал, үнийн санал, нийлүүлэлтийн хугацаа, материалын үзүүлэлт, төсвийн задаргааг ТББ-ын шаардлага бүртэй тулган баталгаажуулж, шаардлага бүрэн хангаагүй тендерийг шалгаруулахгүй байх.

Сүхбаатар сумын Засаг дарга, ЗДТГ-т:

1. Тоног төхөөрөмж худалдан авахтай холбоотой төсөл, арга хэмжээг орон нутгийн төсөвт батлахдаа техникийн тодорхойлолтыг урьдчилан боловсруулж, холбогдох судалгаа, тооцоотой нь хамт бүрдүүлсний дараа баталж хэвшүүлэх.

---oOo---